



**ХЭНТИЙ АЙМГИЙН
ХЭРЛЭН СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ**

2024 оны 02 сарын 07 өдөр

Дугаар А/68

Чингис хот

Хөрөнгө зарцуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.3, Хэрлэн сумын Засаг даргын 2020-2024 онд хэрэгжүүлэх үйл ажиллагааны хөтөлбөрийн 2 дугаар зүйлийн 2.3.6, 2.3.8, Аймгийн Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрийн 2.4.11 дэх заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь.

1.Хэрлэн сумын Баянмөнх багийн хэвтрийн болон асаргаанд байдаг, нийгмийн хамгаалал шаардлагатай (ахмад настан 54, зорилтот бүлгийн 27) өрхүүдэд гэр айлчлал хийх, төрийн үйлчилгээг хүргэх ажлын хүрээнд хэрэгжүүлэх гэр эргэлтэд зарцуулагдах зардлыг хавсралтаар баталсугай.

2.Баянмөнх багийн тусламж дэмжлэг шаардлагатай айл өрхүүдээр айлчлах, гэр эргэлт хийх үйл ажиллагаанд зарцуулагдах 540 000 (Таван зуун дөчин мянган) төгрөгийг Засаг даргын мөрийн хөтөлбөрт тусгагдсан зарим арга хэмжээг авч хэрэгжүүлэх зардлаас гаргахыг Нягтлан бодогч (Д.Баярцэцэг)-д зөвшөөрсүгэй.

ДАРГА



М.ШҮРЭНЦЭЦЭГ

Хэрлэн сумын Засаг даргын 2024 оны
12 сарын 12 ны өдрийн 02 дүгээр
Захирамжийн хавсралт

Зарцуулагдах зардлын төсөв

д/д	Материалын нэр	Хэмжих нэгж	Тоо ширхэг	Нэг бүрийн үнэ	Нийт үнэ
Хамтарсан багийн гэр зргэлт/ хариу үйлчилгээ					
1	Шатахуун АИ 92	л	79.4	2520	200 000
2	Хариу үйлчилгээний зардал	ш	2	170000	340 000
НИЙТ ТӨСӨВ					540 000